



**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛЪТ ХК



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН  
2023**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023.05.01

Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах бүрэлдэхүүнтэй сонгогдсон бөгөөд Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.2-д зааснаар 2 жилийн хугацаанд компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болж **олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй** удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүд:

ТУЗ	Ердийн гишүүд						Хараат бус гишүүд		
Зураг									
Овог нэр	Л.Ариунболд	Г.Ганзориг	Б.Шаравсамбуу	П.Сайнбилэг	Хан гю бунг	А.Энхгэрэл	Ч.Зоригтбаатар	Ш.Энхтөр	П.Нямдорж
Мэргэжил	Инженер, Эдийн засагч	Цэргийн командлагч, Улс төр судлаач	Нягтлан бодогч, Эдийн засгийн ухааны доктор	Технологийн инженер, Санхүүч	Бизнесийн удирдлагын мастер	Үйлдвэр үйл ажиллагаа, Санхүү менежмент	Хуульч, Эдийн засагч	Эрх зүйч, Банкны удирдлага	Багш, Бизнесийн удирдлага
Ажлын туршлага	Хүнд аж үйлдвэрлэлийн салбарт 36 жил ажилласан. Монгол Базальт ХК-ийг үүсгэн байгуулагч	Баглан хамгаалах салбарт 43 жил ажилласан. 2016 оноос Монгол Базальт ХК-ийн шугам хоолойн дулаалгын төслийн удирдагч	Санхүү эдийн засгийн салбарт 58 жил ажилласан. Худалдаа бэлтгэлийн яамны сайд, улсын их хурлын гишүүнээр ажиллаж байсан.	Банк санхүүгийн салбарт 16 жил ажилласан. 2007-2018 онд Монгол Базальт ХК-ийн санхүү эрхэлсэн захиралаар ажиллаж байсан.	1999-2006 он Хьюндай-Салбарын дарга, 2006 оноос ГАУЛИ ҮЦК-ийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.	2013-2017 он "Монгол Базальт" ХК-ийн Олон улсын төсөл хариуцсан захирал, 2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн Гүйцэтгэх захирал	27 жил хуульчаар ажилласан. 2008 оноос Лекс Коунсел ХХК-Гүйцэтгэх захирал	1997-2009 он Худалдаа Хөгжлийн банк, Хуульч 2013 оноос Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо-Өмгөөлөгч	ХХК-Захирал 2011-2012 он MWTS ХХК-Брокер 2013-2015 он Гацуурт трейд ХХК- Ахлах брокер 2015 он Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-Маркетингийн мэргэжилтэн
Хувьцаа эзэмшлийн хувь	35.7%	0%	0%	13.3%	0.10%	7%	0%	0%	0%
Ирц, оролцоо	100%	100%	100%	100%	Цахим 70%	100%	95%	90%	90%

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч Л.Ариунболд, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар хуульч О.Билгүүн нар ажилласан болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр, П.нямдорж нар нь өөрсдийн салбарт мэдлэг, ур чадвараараа хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд компанийн үйл ажиллагааны онцлогийг ойлгож, цаашдын тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүрэн дэмжсэн хараат бус гишүүний чиг үүргийг зохих ёсоор биелүүлж ажилласныг дурьдах нь зүйтэй.

2021 онд Төлөөлөн удирдах зөвлөл ээлжит болон ээлжит бус 5 хурал хийж, 11 асуудал шийдвэрлэн 6 тогтоол гаргасан байна. Үүнд:

- Ногдол ашиг тараах тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилох

- ТУЗ-ийн үйл ажиллагааны болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам батлах
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, гэрээ байгуулах эрх олгох
- Бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл Хаан банкнаас авах буюу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох
- Компанийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах тухай


Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас нийтийг хамарсан хөл хорио тогтоож, төрийн болон бизнесийн үйл ажиллагаанд цахим хэрэгсэл, онлайн орчныг ашиглах болсон ба манай компани ч ТУЗ-ийн хурлыг ирц бүрэн хийх зорилгоор орон зайнаас үл хамаарч цахим хэрэгсэл ашиглан хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна.

Харин 2022 онд ээлжит болон ээлжит бус 5 хурал, эчнээ санал хураалт 2 удаа явуулж нийт 12 асуудлаар 11 тогтоол баталж, хэрэгжилтийг нь хангасан байна. Үүнд:

- Ногдол ашиг тараах тухай
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай
- Компанийн 2022 оны Бизнес төлөвлөгөө батлах тухай
- Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах тухай
- Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай
- Компанийн удирдлага зохион байгуулалтын бүтэц батлах тухай
- Компанийн засаглал дүрэм, журам батлах тухай
- Хөрөнгийн үнэлгээний тайлан баталгаажуулах тухай

Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцан Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэдэг бөгөөд энэхүү асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Цалин урамшууллын хороо нь тус бүр өөрсдийн чиг үүргийн хүрээнд санал дүгнэлтийг гаргаж танилцуулдаг.

2021-2022 онд гүйцэтгэх удирдлагын баг Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг давуулан биелүүлж, дэлхий нийтийг хамарсан цар тахал, хил гаалийн хорио цээр болон хөрш орны дайны байдлаас шалтгаалсан валютын ханшийн савалгаа, эдийн засгийн хүнд нөхцөлд компанийг үр ашигтай, өндөр бүтээмжтэй ажиллуулсан гэж үзсэн болно.






Монгол базальт ХК нь нээлттэй хувьцаат компани болсоноос хойш хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нарын хөрөнгийг өгөөжтэй байлгах бодлого баримтлан ажилласан ба сүүлийн 4 жил

**НОГДОЛ АШИГ**

Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох / ₮	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%

Ногдол ашгийн өсөлт



2022 оны 12 сард хувьцаа эзэмшигчдийн дансанд 2021 оны ногдол ашиг болох нийт 964,166,530 төгрөгийг олголоо.

ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн нь нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээг байнга нэмэгдүүлсэн байна. Тухайлбал 2021 оны ажлын үр дүнгээр цэвэр ашгийн 60,2 хувь, 2022 оны ажлын үр дүнгээр цэвэр ашгийн 53,4 хувийг тус тус хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон тараасан нь 2022 онд нэгж хувьцаанд 20 төгрөг нь тухайн оны арилжааны банкны хадгаламжийн хүүгээс багагүй байна.

ТУЗ нь энэхүү шийдвэрийг гаргахдаа Компанийн тухай хуульд заасан шаардлагын хэмжээнд санхүүгийн үзүүлэлтийг дүгнэн ирэх оны бизнес төлөвлөгөө, санхүүгийн эх үүсвэр зэргийг судалж, тухайн жилийн инфляци, Монгол банкны бодлогын хүү, хадгаламжийн хүү, хувьцааны үнэ, ханшийн өөрчлөлт гэх мэт эдийн засгийн суурь тооцооллыг хийж, хурлаар хэлэлцдэг.

Мөн 2021 онд компани үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий Атен ХХК-иар, Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт байрлах Ногоон Уулын базальтын ордны дахин үнэлгээг Мөнх-Оргил трейд ХХК-иар тус тус хийлгүүлсэн бөгөөд тайлангийн үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулж, компанийн 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд тусгасан болно.

Компанийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж, шинэ үйлдвэр, үйлдвэрийн дамжлага ашиглалтад орсоноор нийт ажиллагсадын тоо 80 хүрч, ИТА нар нэмэгдсэн тул Компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын схемийг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан. ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 29-ний өдөр Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэцийг хэлэлцсэн ба компанийн цаашдын стратеги төлөвлөгөө, Компанийн засаглалын кодексын зарчмуудад нийцүүлэн засаглалын болон үйл ажиллагааны удирдлагын бүтцийг нэгтгэн схемчилж баталсан юм. Энэхүү схемийн дагуу гүйцэтгэх удирдлагад орон тоо, ажлын байрны ангилал, жагсаалт болон цалин хөлсний интервалыг боловсруулан баталгаажуулах, үйл ажиллагаанд дагаж мөрдөх үүрэг чиглэл өгсөн юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 сарын 31-ны өдрийн хурлаар ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, Аудитын хорооны



### *ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан*

Гишүүдийг сонгосон бөгөөд 2 жилийн хугацаанд компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, хороодын үйл ажиллагааны журамд зааснаар ажилласан байна.

ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн

- Хорооны дарга: Г.Ганзориг
- Гишүүд: П.Нямдорж, Хан Гю Бунг, П.Сайнбилэг

ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн

- Хорооны дарга: П.Нямдорж
- Гишүүд: Ч.Зоригтбаатар, А.Энхгэрэл

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны бүрэлдэхүүн

- Хорооны дарга Б.Шаравсамбуу
- Гишүүд Ч.Зоригтбаатар, Ш.Энхтөр

Нэр дэвшүүлэх хороо нь 2021-2022 онуудад болон 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө дараах ажлуудыг хийж гүйцэтгэн дүгнэлт, санал, зөвлөмж гаргасан байна.

1. Компанийн засаглалын кодексын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Компанийн залгамж халааны бодлого”-ыг боловсруулж, 2023 оны 05 сарын 01-ний өдөр ТУЗ-ийн хурлаар батлуулсан болно.
2. Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмын төслийг шинэчлэн боловсруулж 2022 оны 11 сарын 29-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Энэхүү журамд Компанийн дүрэм, компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлж эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлсон болно.
3. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал хэлэлцсэн тул ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, ТУЗ-ийн хараат бус гишүүний хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, одоогийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь улируулан сонгох нь компанийн тогтвортой хөгжил, компанийн засаглалыг сайжруулах болон стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой гэж санал гаргасаныг ТУЗ-ийн хурлаар дэмжиж шийдвэрлэсэн.
4. Гүйцэтгэх захиралтай 2023-2026 оны 3 жилийн хугацаатай байгуулах Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний төслийг боловсруулж байгаа бөгөөд ТУЗ-ийн хоёрдугаар улирлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам 2022 оны 11 сарын 29-ний өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан ТУЗ-ийн гишүүдийн чиглүүлэх, мэргэшүүлэх, ТУЗ-ин нарийн бичгийн даргын сургалтын төлөвлөгөө гаргаж, 2023 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Цалин урамшууллын хороо нь 2021-2022 онуудад болон 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө дараах ажлуудыг хийж гүйцэтгэн дүгнэлт, санал, зөвлөмж гаргасан байна.

1. Компанийн засаглалын кодексын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Компанийн залгамж халааны бодлого”-ыг боловсруулж, 2022 оны 11 сарын 29-ний өдөр ТУЗ-ийн хурлаар батлуулсан болно.

2. Компанийн Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал олгох дүрэм, журам боловсруулах, батлуулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 оны 2 дугаар улиралд албажуулна.
3. 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тодорхойлсон санал оруулж, 2023.04.17-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулсан.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 сарын 29-ны өдрийн хурлаар Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц шинэчлэн баталсантай холбогдуулан Гүйцэтгэх удирдлагын баг компанийн албан тушаал, ажлын байрны жагсаалт, ангилал, цалин хөлсний дүрэм журмыг шинэчлэх, өөрчлөх ажлыг эхлүүлсэн бөгөөд ТУЗ-ийн цалин урамшууллын хорооноос тухай бүр зөвлөгөө өгч, удирдлагаар ханган ажиллаж байна.
5. Эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын гүйцэтгэлтэй тогтмол хугацаанд танилцан хяналтыг хэрэгжүүлж, ТУЗ-ийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Аудитын хороо нь 2021-2022 онуудад болон 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө дараах ажлуудыг хийж гүйцэтгэн дүгнэлт, санал, зөвлөмж гаргасан байна.

1. Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг Компанийн засаглалын кодексын зарчимд нийцүүлэн боловсруулж 2022 оны 11 сарын 29-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар шинэчлэн батлуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлаар Эрсдлийн удирдлагын хороо байгуулсантай холбогдуулан Аудитын хорооны үйл ажиллагааны журамд дахин нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулалт хийсэн.
2. Компанийн стратеги төлөвлөгөө, цаашдын тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулан Хөндлөнгийн аудитын байгууллагыг СТОУС-ын шаардлага хангасан хэмжээнд шалгаж, дүгнэлт гаргах, олон улсад нэр хүнд бүхий Аудитын байгууллага байхаар сонгон шалгаруулалт явуулж “Нексия глобал монголиа аудит” ХХК-ийг сонгох санал, дүгнэлтийг ТУЗ-өөр хэлэлцүүлж, гэрээ хийх зөвшөөрлийг олгосон. “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК нь Дэлхийн ТОП-8 д ордог аудитын “Nexia International”-ийн Монгол Улс дахь албан ёсны хараат бус гишүүн байгууллага юм. Тус компани нь “Жи Пи Эй глобал монголиа аудит” ХХК гэсэн оноосон нэртэй байсан бөгөөд 2023 онд Сангийн сайдын зөвшөөрлөөр компанийн оноосон нэрийг өөрчилсөн бөгөөд хууль тогтоомжийн шаардлага бүрэн хангасан компани юм.
3. Аудитын хорооны үйл ажиллагааны журамд тусгасаны дагуу хөндлөнгийн аудитын хяналт шалгалтын хугацаанд аудитын хорооны дарга байнгын мэдээлэл солилцож ажилласан бөгөөд 2023 оны 04 сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд Хөндлөнгийн аудитор “Нексия глобал монголиа аудит” ХХК-ийн аудитор Бат-Оргил оролцож ХЭ-ийг мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. Цаашид ч хөндлөнгийн аудитороос нээлттэй мэдээлэл авах боломжийг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нартаа олгож ажиллана.
4. Эрсдлийн удирдлагын хороог ТУЗ-ийн дэргэд байгуулах санал, зөвлөмжийг боловсруулж 2023 оны 05 сарын 01-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрсдлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журмын төслийг боловсруулсан.



*ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан*

5. 2021-2022 онуудад хийгдсэн Их хэмжээний 1 хэлцэл, Сонирхлын зөрчилтэй 2 хэлцэл хийхтэй холбоотой дүгнэлт гаргаж, гэрээний хэрэгжүүлэлтэд зохих хяналтыг тавьж ажилласан.

Монгол базальт ХК-ийн ТУЗ нь 2018 онд нээлттэй хувьцаат компани болсноос хойш Компанийн засалалын кодексын зарчмуудыг баримтлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан Компанийн засаглалын кодексыг бүрэн хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан ажиллаж байна.

2022 онд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний хянан баталгаажилтаар нийт авбал зохих онооны 62 оноо буюу 75 хувиар үнэлэгдсэн бөгөөд 2022 оны 04 сарын 30-ны байдлаар дахин үнэлэхэд 68,5 оноо авах боломжтой байна.

**Үнэлгээний нэгдсэн дүн /өмнөх үнэлгээтэй харьцуулсан байдал/**

№	Кодексын зарчим	Авбал зохих оноо	Анхны үнэлгээ 2022.08	Үнэлсэн оноо 2022.04.30	Хяналтын оноо	Үнэлгээний хувь 2022.04.30
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод тэдгээрийн чиг үүрэг	10	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	5	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	5		83,3%
5	Эрсдлийн удирдлага	8	6	7		87,5%
6	Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	5	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	8		100%
8	Компанийн соёл	6	5	5		83,3%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	9		90%
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>62</b>	<b>68</b>		<b>94,4%</b>



## ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын харилцан уялдаа холбоотой ажиллах нөхцлийг бүрдүүлэх эрх бүхий албан тушаалтан байж дараах ажлыг гүйцэтгэсэн байна.

1. 2021, 2022, 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж Компанийн дүрэмд заасан асуудлыг шийдвэрлүүлсэн.
2. 2021-2023 онуудад Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус 10 хурлыг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулж, 2 удаа эчнээ санал хураалт явуулж, нийт 23 асуудлыг шийдвэрлүүлж, ТУЗ-ийн тогтоол, шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулан батлуулсан байна.
3. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах болон ТУЗ-ийн гишүүд, хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах мэдээлэл боловсруулалт, дамжуулалтыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ирсэн
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын баримт бичгийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, компанийн дүрэм журмын дагуу хөтөлж, архивлах ажлыг гүйцэтгэсэн.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулан зохицуулагч төрийн захиргааны байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулж, компанийн үйл ажиллагааны тухай мэдээллийг гишүүдэд дамжуулж, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажил үүргээ гүйцэтгэх боломж нөхцлийг хангах;
7. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад Компанийн хууль, компанийн засаглалын кодексын зарчмуудын тухай танилцуулах, хууль зүйн мэдлэг олгох сургалтыг жилд нэг удаа, нийт 3 удаа зохион байгуулсан байна.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, мэдээлэл тайланг авч ТУЗ-д танилцуулах ажлыг тогтмол гүйцэтгэсэн.